



**Information
for foreigners**



**Informationen
für die Ausländer**



**Інформація
для іноземців**



**Информация
для иностранцев**




**Thông tin cho
người nước ngoài**



**гадаад иргэдэд
зориулсан мэдээлэл**

Карт № 01	ХОМУТОВ ХОТЫН МЭДЭЭЛЭЛ
Карт № 02	ЧЕХ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИН СУУХ 1
Карт № 03	ЧЕХ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИН СУУХ 2
Карт № 04	ЧЕХ УЛСЫН ИРГЭНИЙ ХАРЪЯАЛАЛ
Карт № 05	БИЧИГ БАРИМТУУД – ГЭР БҮЛ 1
Карт № 06	БИЧИГ БАРИМТУУД – ГЭР БҮЛ 2
Карт № 07	БИЗНЕС ЭРХЛЭХ
Карт № 08	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ
Карт № 09	НИЙГМИЙН ХАНГАМЖ 1
Карт № 10	НИЙГМИЙН ХАНГАМЖ 2
Карт № 11	ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ БА ҮЙЛЧИЛГЭЭ
Карт № 12	БОЛОВСРОЛЫН СИСТЕМ – СУРГУУЛИАС ӨМНӨХ, СУУРЬ, ДУНД БОЛОВСРОЛ
Карт № 13	БОЛОВСРОЛЫН СИСТЕМ – ДЭЭД СУРГУУЛЬ, ГАДААДЫН ДЭЭД БОЛОВСРОЛ БА МЭРГЭЖЛИЙГ ХҮЧИНТЭЙД ТООЦОХ (НОСТРИФИКАЦИ)
Карт № 14	ЗАМ ТЭЭВЭР 1
Карт № 15	ЗАМ ТЭЭВЭР 2
Карт № 16	ХОТЫН ЦАГДААГИЙН ГАЗАР
Карт № 17	ХОТЫН ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ХЭВ ЖУРАМ 1
Карт № 18	ХОТЫН ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ХЭВ ЖУРАМ 2
Карт № 19	ХОМУТОВ ХОТОД БАЙГАА СОЁЛ БА СПОРТ 1
Карт № 20	ХОМУТОВ ХОТОД БАЙГАА СОЁЛ БА СПОРТ 2
Карт № 21	ХОТОД БАЙГАА НИЙТИЙН БАЙГУУЛЛАГУУД – ХОЛБОО БАРИХ
Карт № 22	ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ЗӨВЛӨЛГӨӨ ӨГӨХ ГАДААДЫН ИРГЭДИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВҮҮД



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Chomutov

ХОМУТОВ ХОТЫН МЭДЭЭЛЭЛ

ХОТЫН ГАЗАРЗҮЙН ОРЧИН:

Хомутов хот нь Устецки аймагт Крушне гори уулын хормойд далайн түвшнээс дээш 340 метр өндөрлөгт оршдог засаг захиргааны хувьд хотын статустай бөгөөд 43 хот суурин тосгонтой.

ХОТЫН ҮҮСГЭЛ, ХОТЫН СТАТУС, ХОТЫН ЗАХИРГАА:

Хомутов хот хуучин худалдааны замаас үүсэлтэй. Хомутов хотын тухай анхны тэмдэглэл нь 1252 онд Герман одонт цэргийн бүлэг Хомутов хотыг байгуулсан гэсэн мэдээ байдаг ба мөн 1605 онд бие даасан хотын статустай хааны хот болсон гэж түүхэнд тэмдэглэсэн байдаг. Дэлхийн хоёрдугаар дайны дараа хотын үйлдвэрийн барилга байгууламж төдийгүй хот бүхэлдээ ихээхэн өргөжин томорч 2006 оны 7сарын 1ний өдөр засаг захиргааны хувьд хууль ёсоор хотын статустай болсон. Хоттой холбоотой бүх үйл явцыг хот өөрөө бие даан шийдвэрлэж гүйцэтгэдэг.

Хомутов хотын захиргаа нь сонгуулиар сонгогдсон 35 гишүүнтэй 4 жилийн турш үйл ажиллагаагаа явуулдаг ба хотын захиргааны хурлыг Хомутов хот удирддаг.

Хотын захиргааны 35 гишүүдээс 11 гишүүнтэй хотын захиргааны зөвлөлийг сонгодог ба тэдгээр гишүүд нь хотын дарга болон хотын дэд даргыг сонгож төлөөлүүлдэг.

Хомутов хотын захиргаанд хотын дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, ажилтан нар ажилладаг бөгөөд хотын захиргааны хурал, зөвлөлөөс өгсөн үүрэг даалгавар болон өдөртүтмын үйл ажиллагаагаа тасралтгүй хэрэгжүүлж биелүүлж байдаг. Мөн хотын захиргааны нарийн бичгийн дарга нь зөвлөлөөс гаргасан аливаа шийдвэрийг бие даан эсвэл шилжүүлсэн эрхтэйгээр биелүүлэх үүрэгтэй.

ХОТЫГ ХУВААХ:

Хомутов хотод Хомутов I, Хомутов II хоёр кадастрын хэсэг хамрагдана. Үүнд Бжезенецка, Каменна, Писечна, Захрадни, Задни Винохради, Домовинаь Хорни Вес, Черни Врх, Нове Спожице (Březenecká, Kamenná, Písečná, Zahradní, Zadní Vinohrady a další části Domovína, Horní Ves, Černý vrch a Nové Spojice) зэрэг хотын хэсэг хамрагдана.

ХОТЫН ХИР ХЭМЖЭЭ, ХҮН АМ:

Хомутов хот 29,34 км² талбайтай, 2013 оны 7-р сар 52084 хүн амтай.

ХОТЫН ТЭМДЭГ, ЛОГО:

Бэлэг тэмдгийн хэрэглээ:

Хуулиан дагуу Хомутов хотын бэлэг тэмдэг болон тугыг 128/2000 дугаартай Хот суурин газрын хуулийн 34а болон 142 зүйлийн дүрмийн дагуу хэрэглэж ашиглаж болно. Хомутов хотын бэлэг тэмдэгийг Хомутов хотоос өөр байгууллага, хуулийн ба хувийн этгээд хэрэглэж ашиглахын тулд Хотын бэлэг тэмдэг ашиглах зөвшөөрөл олгох өргөдлийг зөвхөн хотын нарийн бичгийн даргын хэлтэсээр дамжуулан Хомутов хотын захиргааны зөвлөлд өгч зөвшөөрөл авснаар ашиглаж болно.



Лого ашиглах:

Хомутов хотын логоог зөвхөн Хомутов хотын веб сайтууд дээр байгаа график зааварын дагуу ашиглаж болох ба ашиглахын тулд албан бичгээр өргөдөл хотын нарийн бичгийн даргын хэлтэсд өгч баталгаат зөвшөөрөл авснаар ашиглаж болно. Хууль ёсоор Хомутов хотын лого ашиглах зөвшөөрөл олгох өргөдлийг e-мэйл эсвэл www.chomutov-mesto.cz веб сайтууд дээр байгаа маягтаар өгч болно. Мөн лого ашигласан график төсөл үзүүлэх ёстой.



Chomutov

Холбоо:

Magistrát města Chomutova

Хомутов хотын захиргааны газар

хаяг: Zborovská 4602, 430 28 Chomutov

Утас: 474 637 111

E-мэйл: podatelna@chomutov-mesto.cz

Site: <http://www.chomutov-mesto.cz>

ЧЕХ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИН СУУХ 1

ЧЕХ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЕВРОПЫН ХОЛБООНЫ БУСАД ИРГЭД – ГУРАВДАГЧ ОРНЫ ИРГЭДИЙН ОРШИН СУУХ

Гуравдагч гэх орнуудын иргэд Европын Холбооны бусад иргэд буюу Норвеги, Швейцар, Исланд ба Лихтейнштейн иргэд байна.

3 сар хүртэлх оршин суух (богино хугацаагаар оршин суух):

- **визгүй**
- **визтэй**
 - тодорхой зорилгоор виз
 - виз олгохыг хүссэн өргөдлөө зөвхөн өөрийн иргэншилтэй улсад байгаа Чех улсын элчингийн төлөөлөгчийн газарт өгнө
 - БНЧУ-д буюу Шенгений бүс нутагт байх нийт хугацаа хагас жилд 3 сараас илүүгүй байна. (90/180 хоног гэсэн нөхцөлтэй)

3 сараас дээш оршин суух виз:

- **урт хугацааны оршин суух виз**
 - БНЧУ-ын нутаг дэвсгэрт 3 сараас илүү хугацаагаар оршин суух виз
 - виз олгохыг хүссэн өргөдлөө зөвхөн өөрийн иргэншлийн улсад байрлах БНЧУ-ын элчин сайдын яаманд өгөх бөгөөд онцгой тохиолдолд Гадаад иргэдийн оршин суух тухай хуулинд заасанаар зохицуулна
 - визийг тодорхой зорилгоор олгоно (жишээ нь: сурах, ажиллах, бизнес эрхлэх, гэр бүлтэйгээ хамт амьдрах, урилгаар, соёлын, бусад)
 - оршин суух зорилгоо өөрчлөх боломжгүй
 - оршин суух зөвшөөрлийг тодорхой зорилгын дагуу тодорхой хугацаагаар олгоно, дээд хэмжээ нь 6 сар хүртэлх хугацаагаар
 - зөвшөөрсөн оршин суух хугацаа болон олгосон виз хүчинтэй хугацаагаар хязгаарлана
 - (6 сар хүртэл хугацааны виз) болон үүнтэй холбоотой оршин суух зөвшөөрлийг сунгуулж болно
- **удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл**
 - гадаадын иргэн нь доорхи нөхцлүүдийг хангаж байгаа бол удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл Чех улсын Дотоод хэргийн яаманд хүсэх эрхтэй:
 - БНЧУ-д урт хугацааны оршин суух визийн үндсэн дээр оршин сууж байгаа гадаад иргэд
 - БНЧУ-д оршин суух зөвшөөрлийн тодорхой зорилго үргэлжилж буй (онцгой тохиолдлуудад Гадаад иргэдийн оршин суух тухай хуульд зааснаар зохицуулна)
 - Чех улсын нутаг дэвсгэрт 6 сараас илүү хугацаагаар байх эсэхээ урьдаас төлөвлөсөн
 - тодорхой зорилгоор оршин суух зөвшөөрөл (жишээ нь: сурах, ажиллах, бизнес эрхлэх, гэр бүлтэйгээ хамт амьдрах)
 - оршин суух зөвшөөрлийн зорилгыг өөрчилж болно
 - удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийг сунгуулж болно
- **байнга оршин суух зөвшөөрөл**
 - Чех улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар 5 жил тасралтгүй оршин суусан эсвэл Гадаадын харъяатын хуулиар тогтоосон тодорхой тохиолдолд гадаад иргэн байнга оршин суух зөвшөөрөл олгохыг хүсэж болно
 - байнга оршин суух зөвшөөрөл нь хязгааргүй хугацаагаар олгогдоно, зөвшөөрлийн үнэмлэх карт нь тодорхой хугацаанд хүчинтэй байна



БИОХЭМЖҮҮРТИЙН БИЧИГ БАРИМТ:

Удаан хугацаагаар оршин суух болон байнга оршин суух зөвшөөрөлтэй гуравдагч орны иргэд биохэмжүүрийн оршин суух зөвшөөрлийн үнэмлэх карттай байх ёстой. Энэ нь оршин суух зөвшөөрлийн хугацааны турш хүчинтэй.

ГУРАВДАГЧ ОРНЫ ИРГЭДИЙН ҮҮРЭГ:

- гадаад иргэн нь Чех улсын нутаг дэвсгэрт орж ирснээсээ ажлын 3 хонгийн дотор хаягынхаа дагуу Гадаадын харъяатын цагдаагийн газарт (тодорхой нөхцөлд Чех улсын Дотоод хэргийн яаманд) бүртгүүлэх үүрэгтэй
- цагдаагийн газраас шаардсаны хүчинтэй паспорт эсвэл оршин суух зөвшөөрлийн картыг үзүүлэх үүрэгтэй
- Чех улсын нутаг дэвсгэрт удаан хугацаагаар оршин суух виз юмуу удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн үндсэн дээр байгаа гадаад иргэд нь хэрэв оршин суугаа газрын өөрчлөлт 30 хоногоос илүү байхаар бол өөрчлөлт гарснаас 30 хоногийн дотор цагдаагийн газарт мэдэгдэх үүрэгтэй
- оршин суугаа газрын өөрчлөлтийн хувьд хэрэв байнга оршин суух зөвшөөрөл олгогдсон гадаад иргэний бүртгэлтэй газрын өөрчлөлт 180 хоногоос их байхаар бол өөрчлөлт гарснаас 30 хоногий дотор тус өөрчлөлтийг мэдэгдэх үүрэгтэй.
- паспорт, нэр, овог, хувийн байдал зэрэг оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний картын дээр байгаа мэдээллийн өөрчлөлт гарснаас 3 хоногийн дотор тус өөрчлөлтийг мэдэгдэх үүрэгтэй. Визгүй эсвэл богино хугацааны визтэй гадаад иргэн өөрчлөлтийг Гадаад харъяатын цагдаагийн газарт мэдэгдэнэ. Удаан хугацаагаар оршин суух виз, удаан хугацаагаар оршин суух болон байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаад иргэн өөрчлөлтийг Чех улсын Дотоод хэргийн яаманд мэдэгдэнэ
- оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний карт гээх, хаях, хүлгайлан алдах зэрэг үгүй болгох өөрчлөлт гарснаас 3 хоногийн дотор тус өөрчлөлтийг Чех улсын Дотоод хэргийн яаманд мэдэгдэх үүрэгтэй

Дэлгэрэнгүй: Чех улсын Дотоод хэргийн яам

Цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилтын алба

Гадаад иргэдийн оршин суух асуудлыг хариуцсан хэлтэс (харъяат газар: „okresy Chomutov, Louny a Most“ – Хомутов, Лоуни, Мост бүс нутаг)

хаяг: Jiráskova 5338, 430 03 Chomutov

Утас: 974 443 158 (утсаар утсаар захиалгаа өгч болно)

Е-мэйл: daniel.potocky@mvcr.cz

www: <http://www.mvcr.cz/cizinci>

Гадаадын харъяатын цагдаагийн хэлтэс

Гадаад иргэдийн оршин суух асуудлыг хариуцсан хэлтэс

(харъяат газар: „okresy Chomutov, Louny, Most“ – Хомутов, Лоуни, Мост бүс нутаг)

хаяг: Riegrova 4510, 430 01 Chomutov

Утас: 974 433 804

Е-мэйл: icpchomutov@mvcr.cz

www: <http://www.mvcr.cz/clanek/kontakty-774199.aspx>

ЧЕХ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИН СУУХ 2

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ИРГЭД БА ТҮҮНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ЧЕХ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИН СУУХ

Европын Холбооны иргэн бол Европын Холбооны гишүүн орнуудын иргэн байна. Мөн Норвеги, Швейцар, Исланд ба Лихтейнштейн иргэд Европын Холбооны иргэдтэй адилхан эрх үүрэгтэй.

Европын Холбооны гишүүн орнуудын иргэний гэр бүлийн гишүүн, бол Гадаадын иргэд оршин суух тухай хуулиар тогтоосон нөхцөлүүдийг хангасан Европын Холбооны эсвэл Норвеги, Швейцар, Исланд буюу Лихтейнштейн улсын иргэний гэр бүл эсвэл дотоод хүн байна.

ТҮР ХУГАЦААГААР ОРШИН СУУХ:

- Европын Холбооны гишүүн орнуудын иргэд Чех улсын нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүйгээр (зөвхөн паспорт эсвэл үнэмлэхтэй) түр хугацаагаар оршин сууж болно
- Европын Холбооны эсвэл Норвеги, Швейцар, Исланд буюу Лихтейнштейн улсын иргэн Чех улсын нутаг дэвсгэрт 3 сараас илүү хугацаагаар оршин суух гэж байгаа бол түр хугацаагаар оршин суух гэж буй бол оршин суух тухай тодорхойлолт хүснэ
- Европын Холбооны гишүүн орнуудын иргэний гэр бүлийн гишүүн Чех улсын нутаг дэвсгэрт 3 сараас илүү хугацаагаар Европын Холбооны иргэдтэй хамт оршин суух гэж байгаа бол түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгох тухай өргөдөл гаргана
- Европын Холбооны иргэний гэр бүлийн гишүүний түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл бүхий оршин суух карт байна, дээд хугацаа нь 5 жил байна

БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ:

- Европын Холбооны иргэн болон түүний гэр бүлийн гишүүн хуулиар тогтоосон тохиолдолд байнга оршин суух зөвшөөрөл олгох өргөдлөө гаргаж болно
- Европын Холбооны иргэн доор дурьдсан тохиолдолд байнга оршин суух зөвшөөрөл хүссэн өргөдлөө гаргаж болно:
 - Чех улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар 5 жил тасралтгүй оршин суусан бол
 - Чех улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар 2 жил тасралтгүй оршин суусан, хэрэв өргөдөл гаргагч нь Европын Холбооны гишүүн өөр орны иргэний гэр бүлийн гишүүн бол
- Европын Холбооны иргэний гэр бүлийн гишүүн ялангуяа доод дурдсан тохиолдолд байнга оршин суух зөвшөөрөл олгох өргөдлөө гаргаж болно:
 - Чех улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар 5 жил тасралтгүй оршин суусан бол
 - Чех улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар 2 жил тасралтгүй оршин суусан, хэрэв өргөдөл гаргагч нь Чех улсын иргэний гэр бүлийн гишүүн эсвэл Европын Холбооны гишүүн өөр орны иргэний гэр бүлийн гишүүн бол

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ИРГЭД БА ТҮҮНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙ ЭРХ ҮҮРЭГ:

- Чех улсын нутаг дэвсгэрт орж ирснээсээ ажлын 30 хоног дотор Гадаадын харъяатын цагдаагийн байгууллагын хэлтэст - цагдаагийн газарт оршин суугаа хаягаа мэдэгдэх үүрэгтэй
- цагдаагийн газраас шаардахад хүчинтэй паспорт, хувийн үнэмлэх эсвэл Европын Холбооны иргэний байнга оршин суух зөвшөөрлийн картыг үзүүлэх үүрэгтэй
- оршин суугаа газрын өөрчлөлтийн хувьд хэрэв байнга оршин суух зөвшөөрөл олгогдсон гадаад иргэний бүртгэлтэй газрын өөрчлөлт 180 хоногоос их байхаар бол өөрчлөлт гарснаас 30 хоногийн дотор тус өөрчлөлтийг мэдэгдэх үүрэгтэй



- паспорт, хувийн үнэмлэх, нэр, овог, хувийн байдал зэрэг түр/байнга оршин суух зөвшөөрлийн картын дээр байгаа мэдээллийн өөрчлөлт гарснаас 15 хоногийн дотор тус өөрчлөлтийг мэдэгдэх үүрэгтэй. Визгүй гадаад иргэн өөрчлөлтийг Гадаад харьяатын цагдаагийн газарт мэдэгдэнэ. Түр хугацаагаар оршин суух виз, түр хугацаагаар оршин суух болон байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаад иргэн өөрчлөлтийг Чех улсын Дотоод хэргийн яаманд мэдэгдэнэ
- оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний карт гээх, хаях, хулгайлд алдах зэрэг үгүй болгох өөрчлөлт гарснаас 3 хоногийн дотор тус өөрчлөлтийг Чех улсын Дотоод хэргийн яаманд мэдэгдэх үүрэгтэй

Дэлгэрэнгүй: Чех улсын Дотоод хэргийн яам

Цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилтын алба

Гадаад иргэдийн оршин суух асуудлыг хариуцсан хэлтэс (харьяат газар: „okresy Chomutov, Louny a Most“ – Хомутов, Лоуни, Мост бүс нутаг)

хаяг: Jiráskova 5338, 430 03 Chomutov

Утас: 974 443 158 (утсаар утсаар захиалага өгч болно)

Е-мэйл: daniel.potocky@mvcr.cz

www: <http://www.mvcr.cz/cizinci>

Гадаадын харьяатын цагдаагийн хэлтэс

Гадаад иргэдийн оршин суух асуудлыг хариуцсан хэлтэс

(харьяат газар: „okresy Chomutov, Louny, Most“ – Хомутов, Лоуни, Мост бүс нутаг)

хаяг: Riegrova 4510, 430 01 Chomutov

Утас: 974 433 804

Е-мэйл: icpchomutov@mvcr.cz

www: <http://www.mvcr.cz/clanek/kontakty-774199.aspx>

БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН ХАРЬААТ ИРГЭН БОЛОХ

Бүгд Найрамдах Чех Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин сууж буй гадаад улсын харьяат иргэд БНЧУ-ын иргэний харьяалал олгохыг хүсэх эсвэл БНЧУ-ын харьяат иргэн болоход зориулсан нөхцлүүдийг мэдэгдэл гарган биелүүлж болно.

ИРГЭНИЙ ХАРЬААЛАЛ ОЛГОХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛД ТАВИГДАХ НӨХЦЛҮҮД:

- а) өргөдөл гаргах өдөр гадаадын иргэний БНЧУ-ын нутаг дэвсгэр дээр байнга оршин суух зөвшөөрөл тасралтгүй:
 - 5-аас доошгүй жил
 - БНЧУ-ын нутаг дэвсгэр дээр оршин суух өмнөх зөвшөөрлийн хамт 10-аас доошгүй жил
 - Европын Холбооны иргэн 3-аас доошгүй жил
 - б) гадаадын иргэн БНЧУ-ын нутаг дэвсгэр дээр оршин суух хугацааны талаас доошгүй хугацаанд үнэхээр амьдарч байгаагаа нотолно
 - в) гадаадын иргэн болгоомжгүй эсвэл санаатай үйлдсэн гэмт хэрэгт хорих ял эдэлж байгаагүй
 - г) гадаадын иргэн (15-65 нас) чех хэл болон БНЧУ-ын талаар суурь мэдлэгээ харуулна
 - д) гадаадын иргэн сүүлийн 3 жилд нийтийн эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгал, тэтгэврийн даатгал, татвар, төлбөр болон хураамж төлөх зэрэг хуулийн тусгай журмын тогтоомжуудаас үүдэн гарах үүргээ биелүүлнэ
 - е) гадаадын иргэн (18-аас дээш настай) сүүлийн 3 жилийн орлогын хэмжээ болон эх үүсвэрээ үзүүлэх ёстой
 - ё) гадаадын иргэн сүүлийн 3 жилд ноцтой шалтгаангүйгээр улсын нийгмийн халамжийн эсвэл эд мөнгөний гачигдалд туслах тогтолцоонд хүндрэл учруулаагүй
- Тодорхой тохиолдолд зарим нөхцлүүдийн биелэлтийг уучлан үзэж болно. В) болон е)-д заасан нөхцлүүдийг уучилж болохгүй.

Өргөдлийн агуулга: хэн өргөдөл гаргаж байгаа, хэнд зориулагдаж буй, юуны тухай, үндэслэл, хүссэн үр дүн, он сар өдөр ба өргөдөл гаргагчийн гарын үсэг. Өргөдөл бичих маягт байдаггүй тул өргөдөл гаргагч нь чөлөөт хэлбэрээр бичиж гаргана.

ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС:

- бөглөсөн маягт (холбогдох албанд өргөдөл гаргагч маягт хүлээн авч, бөглөнө)
 - төрсний гэрчилгээ
 - гэрлэлтийн баталгаа, гэрлэлт цуцалсан тухай баримт эсвэл эхнэр/нөхрийн нас барсны гэрчилгээ
 - чех хэл болон БНЧУ-ын талаар суурь мэдлэгийг нотолсон баримт
 - намтар
 - хувийн нөхцөл байдлыг харгалзан өөр бусад бичиг баримт
- Өргөдөл гаргагч нь БНЧУ-ын харьяат иргэн болохыг хүссэн өргөдлөө **Уустий аймгийн Аймгийн захиргаанд** (эсвэл өргөдөл гаргагчийн байнга оршин суух газрын холбогдох байгууллагад) гаргана.

БНЧУ-ын Дотоод яам өргөдлийн талаар түүнийг хүлээн авсан өдрөөс 180 хоногийн дотор шийдвэрлэж, БНЧУ-ын иргэний харьяаллыг олгоно. Өргөдөл нь үнэ төлбөргүй бөгөөд **БНЧУ-ын иргэний харьяалал олгох тухай албан бичиг** олгоход захиргааны хураамж 2 000 чех крон төлнө. Үндэслэж тайлбарласан тохиолдолд захиргааны хураамжийг 500 хүртэл чех кроноор бүүруулж болно. Өргөдлийг үл зөвшөөрсөн тохиолдолд захиргааны хураамж төлөхгүй ба өргөдөл гаргагч нь 2 жил өнгөрсний дараа шинэ өргөдөл гаргаж болно.



МЭДЭГДЭЛ ГАРГАН БНЧУ-ЫН ХАРЬААТ ИРГЭН БОЛОХ (2 ДАХЬ ҮЕ):

БНЧУ-ын нутаг дэвсгэр дээр **10-аас дээшгүй наснаас** мэдэгдэл гаргах өдөр хүртэл гуравны хоёроос доошгүй хугацаанд зүй ёсоор оршин сууж буй БНЧУ-ын нутаг дэвсгэр дээр байнга оршин суух зөвшөөрөлтэй **18-21 насны** гадаадын иргэд хэрэглэж болох иргэний харьяалал олж авах хялбарчилсан арга юм. Гадаадын иргэн мэдэгдэлд гэмт хэрэгт ял шийтгүүлээгүй гэдгээ нотлох ёстой.

Дэлгэрэнгүй:

Уустий аймгийн Аймгийн захиргаа

Захиргааны үйл ажиллагааны тасаг ба аймгийн лиценз бүртгэлийн алба

Захиргааны үйл ажиллагааны хэлтэс

хаяг: Velká Hradební 3118/48, 400 02 Ústí nad Labem

Утас: 475 657 307

Е-мэйл: urad@kr-ustecky.cz

http://www.kr-ustecky.cz/vismo/zobraz_dok.asp?id_org=450018&id_ktg=62107&p1=89260

Чех хэл болон БНЧУ-ын талаар суурь мэдлэгийн шалгалтын мэдээлэл:

<http://obcanstvi.cestina-pro-cizince.cz/>

БИЧИГ БАРИМТУУД – ГЭР БҮЛ 1

Хүүхэд төрөх, гэрлэлт бүртгүүлэх, нас барах зэрэг гэр бүлийн тохиолдолд тохиолдох захиргааны харъяа гэр бүлийн товчоо гэр бүлийн бичиг баримтуудыг өгнө.

ТӨРСНИЙ ГЭРЧИЛГЭЭ:

- **ээж гэрлэсэн бол:**
 - гэрлэлтийн гэрчилгээ, паспорт эсвэл оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний карт
 - хүүхдийн нэр тодорхойлохын тухай аав ээж хоёрын шийдвэр
 - хүүхдийн овог тодорхойлохын тухай аав ээж хоёрын шийдвэр
- **ээж гэрлээгүй бол:**
 - аав ээж хоёрын төрсний гэрчилгээ
 - паспорт эсвэл оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний карт
 - салалтын шийдвэр эсвэл нөхрийн нас барсны гэрчилгээ
 - хүүхдийн нэр тодорхойлохын тухай аав ээж хоёрын шийдвэр
 - хүүхдийн овог тодорхойлохын тухай аав ээж хоёрын шийдвэр
 - хүүхэд төрөхөөс өмнө жирэмсний үнэмлэх
- **ээж гэрлээгүй бол, аав мэдэхгүй хүн бол:**
 - хүүхдийн нэр тодорхойлохын тухай шийдвэр
 - төрсний гэрчилгээ
 - салалтын шийдвэр эсвэл нөхрийн нас барсны гэрчилгээ
 - паспорт эсвэл оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний карт

Төрсний гэрчилгээ гаргахад өргөдөл гаргагч захиргааны хураамж нь төлөхгүй.

НАС БАРСНЫ ГЭРЧИЛГЭЭ:

Нас барсны гэрчилгээ - талийгаачийн гэр бүлийн гишүүдэд (нөхөр, эцэг эх, хүүхдүүд, өвөг эцэг, эх, ач ба гучууд) эсвэл түүний төрсөн ах дүүд эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд эсвэл төрсөн өдөр хамт амьдрадаг этгээдэд олгоно.

Нас барсны гэрчилгээ олгоход тохиолдолд хэрэгтэй:

- талийгаачийн иргэний үнэмлэх эсвэл паспорт эсвэл оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний карт
 - талийгаачийн төрсний гэрчилгээ эсвэл гэрлэлтийн гэрчилгээ эсвэл салалтын шийдвэр эсвэл талийгаачийн нөхрийн нас барсны гэрчилгээ
 - гэр бүлийн товчоонд талийгаачийн жолооны үнэмлэх болон даатгалын үнэмлэх буцаж өгч болно
- Нас барсны гэрчилгээ гаргахад өргөдөл гаргагч захиргааны хураамж нь төлөхгүй.*

БИЧИГ БАРИМТУУДЫН ХУУЛБАР - ТӨРСНИЙ ГЭРЧИЛГЭЭ, ГЭРЛЭЛТИЙН ГЭРЧИЛГЭЭ, НАС БАРСНЫ ГЭРЧИЛГЭЭ:

Бичиг баримтуудын хуулбар авахад хэрэгтэй:

- паспорт эсвэл оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний карт
 - гэр бүлийн бичиг баримтуудыг мөн гэр бүлийн гишүүдэд (нөхөр, эцэг эх, хүүхдүүд, өвөг эцэг, эх, ач ба гучууд) эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд эсвэл бичиг баримттай холбоотой этгээдэд олгож болно
 - өргөдлөө бичгийн аргаар гаргавал өргөдөл гөргөгч гарын үсгээ зурах ёстой
- Өргөдлөө бичгийн аргаар гаргавал өргөдөл гөргөгч гарын үсгээ зурах ёстой Захиргааны хураамж нь 100 крон байдаг.*



Дэлгэрэнгүй:

Magistrát města Chomutova – Oddělení správních činností, matrika

Хомутов хотын захиргааны газар – Захиргааны хэлтэс, Гэр бүлийн товчоо

хаяг: Zborovská 4602, 430 28 Chomutov

Утас: 474 637 117 - 120

Е-мэйл: podatelna@chomutov-mesto.cz

www: <http://www.chomutov-mesto.cz>

БИЧИГ БАРИМТУУД – ГЭР БҮЛ 2

ГЭРЛЭЛТ БАТЛУУЛАХ:

Чех улсын иргэн болон гадаад хүн эсвэл хоёр гадаад хүний сүйт хос:

- хүн бүр өөрийн төрсний гэрчилгээ
- улсын харъяалал тухай гэрчилгээ (гадаад хүн)
- гэрлэхэд хуулийн эрхтэй байдлын тодорхойлолт (гэр бүл батлуулах өдрөөс 6 сарын хуучингүй байх ёстой)
- гадаад улсаас гарсан хувийн байдал болон оршин суухын тухай тодорхойлолт
- нас барсан нөхрийн нас барсны гэрчилгээ (хэрэв хуулийн эрхтэй байдлын тодорхойлолтод байхгүй бол)
- гадаад хүн салсан бол салсны тухай шийдвэр
- гадаад хүн гэр бүл бүртгүүлэх байдалд амьдрасан бол гэр бүл бүртгүүлснийг цуцалсан тухай шүүхийн шийдвэр эсвэл нөхрийн нас барсны гэрчилгээ
- паспорт эсвэл иргэний үнэмлэх
- Чех улсын нутаг дэвсгэрт оршин суух эрхтэй тухай олгосон тодорхойлолт (хэрэв Европын Холбооны иргэн, Европын эдийн засгийн бүсийн тухай Хэлэлцээрийн гэрээхий өөр орны иргэн эсвэл түүний гэр бүлийн гишүүдэд хамаарахгүй), энэ тодорхойлолт нь гэр бүл батлуулах өдрөөс 7 ажлын өдрөөс хуучингүй байх ёстой

Хураамж нь:

- **Хураамжгүй** – өмнөх тогтоосон цагт ёслолын танхимд гэр бүл батлуулах ёс заншил гүйцэтгэнэ
- **Захиргааны хураамж нь 1000 крон** – тогтоосон ёслолын танхимаас өөр газарт эсвэл тогтоосон хугацаагаас өөр цагт гэр бүл батлуулахыг зөвшөөрөл
- **Захиргааны хураамж нь 2000 крон** – сүйт хосоос зөвхөн нэг иргэн нь Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух байдалтай бол
- **Захиргааны хураамж нь 3000 крон** – сүйт хосоос аль нэг нь Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух байдалгүй бол

ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ:

15-аас дээш насны Чех улсын иргэн иргэний үнэмлэх олгох тухай өргөдөл гаргаж болно, 15-доош насны өргөдөл гаргагчын оронд түүний хуулиар тогтоосон төлөөлөгч (аав ээж хоёр) өргөдөл гаргаж болно.

Өргөдлөө бичгийн аргаар бөглөхгүй (албан газрын ажилтныг бөглөсөн анкет хэвлэхэд иргэн гарын үсгээ зурж анкетыг зөвшөөрнө), иргэний гэрэл зураг албан газрын ажилтан хийнэ.

Иргэний үнэмлэх олгох тухай өргөдөл гаргахад зөвхөн төрсний гэрчилгээ үзүүлнэ. 15-аас дээш насны Чех улсын иргэн анхны иргэний үнэмлэхээ олгох үед захиргааны хураамж төлөхгүй (15-доош насны хүүхэд - өргөдөл гаргагч 50 кроны захиргааны хураамж төлнө).

Дэлгэрэнгүй:

Magistrát města Chomutova – Oddělení správních činností – občanské průkazy

Хомутов хотын захиргааны газар – Захиргааны хэлтэс – иргэний үнэмлэх

хаяг: Zborovská 4602, 430 28 Chomutov

Утас: 474 637 117–120

Е-мэйл: podatelna@chomutov-mesto.cz

www: <http://www.chomutov-mesto.cz>

БИЗНЕС ЭРХЛЭХ

АЖ АХУЙН ЭРХЛЭХИЙН ТӨРӨЛ – БНЧУ-ын нутаг дэвсгэрт бизнес эрхлэх 2 төрлийн боломжтой:

- а) „fyzická osoba“ гэх хувийн этгээд – хувиараа хөдөлмөр эрхлэгч этгээд (OSVČ) – БНЧУ-ын иргэн, оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн, оршин суух зөвшөөрөлгүй гадаадын иргэн (бизнес эрхлэснээс хойш БНЧУ-ын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрлийг хагас жилийн дотор үзүүлэх ёстой)
- б) „právnická osoba“ гэх хуулийн этгээд – хөдөлмөрийн байгууллага – хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувьцаат компани зэрэг байгууллагууд, худалдааны компаниуд

ХУУЛИАР АНГИЛАН ЯЛГАДАГ:

- урьдчилан мэдэгдэж аж ахуй эрхлэх (чөлөөтэй, нарийн мэргэжлийн, чөлөөгүй)
- концессээр аж ахуй эрхлэх

КОНЦЕССИЙН ӨРГӨДӨЛ – Урьдчилан мэдэгдэх ба концессийн өргөдлийг өөрийн биеэр харъяа суурингийн аль ч лиценцийн албанд өгч болно:

Хувь хүн бол :

иргэний үнэмлэх эсвэл паспорт, нарийн мэргэжлийн гэрчилгээ (шаардлагатай бол хариуцлагатай төлөөлөгчийн нарийн мэргэжлийн тодорхойлолт), хувийн этгээдийн бизнес эрхлэхийг зөвшөөрсөн газрын тодорхойлолт, (шаардлагатай бол хариуцлагатай төлөөлөгчийн тодорхойлолт), захиргааны хураамж төлсөн баримт

Хуулийн этгээд бол:

хуулийн этгээдийн нэрээр үйл ажиллагаа явуулж буй төлөөлөгчийн иргэний үнэмлэх эсвэл паспорт, нарийн мэргэжлийн гэрчилгээ/шаардлагатай бол хариуцлагатай төлөөлөгчийн нарийн мэргэжлийн тодорхойлолт, байгууллагын гэрчилгээ (Улсын худалдааны эсвэл адилхан цэсэнд бичүүлээгүй бол), түс байгууллагын бизнес эрхлэхийг зөвшөөрч буй газрын тодорхойлолт, шаардлагатай бол хариуцлагатай төлөөлөгчийн тодорхойлолт, захиргааны хураамж төлсөн баримт

Бизнес эрхлэгч нь ямар нэг өөрчлөлт гарвал 15 хоногийн дотор харъяа суурингийн аль ч лиценцийн албанд мэдэгдэх үүрэгтэй.

БИЗНЕС ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТҮР ХУГАЦААГААР ЗОГСООХ БОЛОН ШИНЭЧЛЭХ:

Бизнес эрхлэгч нь үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоох болсноо мэдэгдэх үүрэгтэй ба үүнийг зөвхөн хүчинтэй оршин суух зөвшөөрлийн хугацааны хүртэл гүйцэтгэж болно.

Бизнес эрхлэгч нь үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоосны дараа дахин шинээр эхэлвэл харъяа суурингийн аль ч лиценцийн албанд заавал мэдэгдэх үүрэгтэй.

АЖ АХУЙ ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ ЦУЦЛАХ:

Бизнес эрхэлсэн этгээд аж ахуй эрхлэх зөвшөөрлийг цуцламаар байвал харъяа суурингийн аль ч лиценцийн албанд аж ахуй эрхлэх зөвшөөрлийг цуцлах тухай өргөдөл гаргаж болно.

Аж ахуй эрхэлсэн этгээд Санхүүгийн албан газар – татварын хэлтэс, Нийгмийн халамжийн албан газарт болон Эрүүл мэндийн даатгалын газарт бүртгүүлэх үүрэгтэй.



Дэлгэрэнгүй:

Magistrát města Chomutova, Obecní živnostenský úřad

Хомутов хотын захиргааны газар – Харъяа лицензийн алба

хаяг: Husovo náměstí 104/1, 430 28 Chomutov

Утас: 474 637 983–986, 979

Е-мэйл: podnikani@chomutov-mesto.cz

<http://www.chomutov-mesto.cz>

<http://www.mpo.cz>

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ

АЖЛЫН БАЙР ЭРЭХ БОЛОМЖ:

Хөдөлмөрийн товчоо (ҮР)

БНЧУ-ын **Хөдөлмөрийн биржийн** харъяа мужийн салбарт **ажил хайгчдийн** бүртгэлд бүртгүүлж ажлын байрыг үнэ төлбөргүй дамжуулан олох болно:

- байнга болон түр хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй Европын Холбооны иргэд эсвэл түүний гэр бүлийн гишүүн
- байнга оршин суух зөвшөөрөлтэй Гуравдагч орнуудын гадаадын иргэд

Та ажил хайгчдийн бүртгэлд бүртгүүлвэл Хөдөлмөрийн биржтэй хамтран ажиллаж эрүүл мэндийн даатгалыг улсаас нөхөн төлүүлэх боломжтой болно.

Хөдөлмөрийн товчоодоос гадна ажил хайхдаа ажил үнэ төлбөргүй болон төлбөртэй зуучлахад **хөдөлмөрийн агентлагуудын үйлчилгээг** бас ашиглаж болно. Байнга оршин суух зөвшөөрөлтэй Гуравдагч орнуудын гадаадын иргэдийг ажиллуулж болно.

Мөн ажлыг өдөр тутмын **зарын сонин болон интернэтийн зарууд** зэрэг олон аргаар олох боломжтой.

АЖИЛЛАХ ЗӨВШӨӨРӨЛ:

Энэ үүрэг нь байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаад иргэн дүрвэгсдийн статус олгосон юмуу орогнох эрх эсвэл нэмэлт хамгаалалттай байгаа гадаад иргэн ба байнга оршин суух эсвэл дүрвэгсдийн статус олгогдсон гадаад иргэний гэр бүлтэй хамт амьдрах зорилгоор БНЧУ-д удаан хугацаагаар амьдрах зөвшөөрөлтэй гадаад иргэнд хамаарахгүй. Мөн БНЧУ-ын нутаг дэвсгэрт өдөр буюу өдрийн хэлбэрээр дунд/дээд сургуульд суралцдаг **Гуравдагч орнуудын гадаадын иргэнээс ажиллах зөвшөөрөл шаардахгүй.**

Гуравдагч орнуудын гадаадын иргэд бичгээр ажиллах зөвшөөрөл олгох тухай өргөдөлийг **Хөдөлмөрийн биржийн** харъяа мужийн салбарт гаргана:

- гадаад иргэн нь түүнийг энэ ажлыг хийхэд дотоодын хуулийн юмуу хувь этгээдтэй байгуулсан худалдааны эсвэл өөр гэрээний үндсэн дээр гадаадын ажил олгогчтой хөдөлмөрийн харьцаанд БНЧУ-ын нутаг дэвсгэрт ажил хийх бол мөн ажиллах зөвшөөрөл шаардлагатай
- ажлын сул орон тоо БНЧУ, Европын Холбоо эсвэл тогтоосон улсын иргэдээс авч ажиллуулах боломжгүй болсны дараа ажиллах зөвшөөрөл олгоно Өргөдөл өгөхдөө (бичиг баримтуудын эх хувь болон чех хэлээр албан ёсны орчуулгаар үзүүлдэг) бичиг баримтууд хэрэгтэй:
 - а) ажил олгогчийн гадаад иргэнийг цаашид ажиллуулах гэсэн бичиг баримт
 - б) тус ажлын байранд ажиллахад нарийн мэргэжлийн тодорхойлолт
 - в) шаардлагатай бол өөр бичиг баримт

БНЧУ-ын нутаг дэвсгэрт ажиллах зөвшөөрлийг тодорхой хугацаагаар, цаад тал нь 2 жилийн хугацаатай олгоно. Ажиллах зөвшөөрлийг нь сунгаж болно, гэхдээ цаад тал нь 2 жилийн хугацаагаар.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ:

Хөдөлмөрийн харьцаа ажилтан ажил олгогчтойгоо хөдөлмөрийн гэрээ байгуулснаар үүсгэдэг. Хөдөлмөрийн гэрээнд ажил олгогч гол зүйлүүдийг, энэ нь ажлын төрөл, ажил хийж гүйцэтгэх газар ба ажилд орох өдөр, ажилтантай тохиролцох ёстой. Гэрээ зөвхөн ажил олгогч ажилтан хоёр хэлэлцээгээр бичгээр нэмэж өөрчилж болно. Юуны түрүүнд бичгээр хийгдсэн байх ёстой.

Таны ажил олгогч таны эрүүл мэндийн болон нийгмийн даатгал төлөх үүрэгтэй.

Хөдөлмөрийн харьцаа үүсгэдэг:

- тодорхой бус хугацаагаар, хөдөлмөрийн харьцаагийн хугацаа хязгаарлагдсан биш байна
- тодорхой хугацаагаар, хөдөлмөрийн харьцаагийн хугацаа хязгаарлагдсан байна

Хөдөлмөрийн харьцаанаас гадна хийх ажлын тухай гэрээ (бичгээр хийгдсэн байх ёстой):

- ажил гүйцэтгэх тухай гэрээ (ажлын хэмжээ нэг ажил олгогч дээр хүнлийн жилд 300 цагаас хэтрэхгүй)
- хөдөлмөрийн үйл ажиллагааны тухай гэрээ (үүнийг хамгийн ихээр долоо хоногийн ажлын хугацааны хагаст байхаар тодорхой ажил олгогчтой хийж болно)

Дэлгэрэнгүй:

Úřad práce České republiky, Krajská pobočka v Ústí nad Labem

Чех улсын хөдөлмөрийн товчоо, Усти над Лабем мужийн салбар

Kontaktní pracoviště Chomutov

Хомутовд байгаа товчоо

хаяг: Cihlářská 4107, 430 03 Chomutov

Утас: 950 118 111

Е-мэйл: chomutov@cv.mpsv.cz

www: <http://portal.mpsv.cz/upcr/kp/ulk/kop/chomutov>

НИЙГМИЙН ХАНГАМЖ 1

НИЙГМИЙН ХАНГАМЖИЙН СИСТЕМ:

Нийгмийн даатгалд хамрагдана:

- тэтгэмжийн даатгал
- тэтгэврийн даатгал
- улсаас нэмэгдэлтэй тэтгэврийн нэмэлт даатгал

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛ:

Чех улсын нутаг дэвсгэрт ажиллаж байгаа ажилтнууд - Чех улсын иргэн болон гадаад хүмүүс хуулийн дагуу тэтгэмжийн даатгалд заавал оролцоно. Хувиара хөдөлмөр эрхэлдэг этгээдүүд тэтгэмжийн даатгалд дураараа оролцоно.

Чех улсын/Европын Холбооны/нийгмийн халамжийн тухай олон улсын гэрээ байгуулсан өөр гадаад улсын нутаг дэвсгэрт албан ёсны хаягтай эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй ажил олоогчийн гадаад хүн – ажилтан тэтгэмжийн даатгалд оролцоно.

Ажилтаны оронд түүний ажил олгогч, хувиара хөдөлмөр эрхэлдэг этгээдүүд өөрөө тэтгэмжийн даатгалын системд бүртгүүлнэ.

Тэтгэмжийн даатгалаас ажилтнуудад 4 төрлийн тэтгэмж олгодог:

- хөдөлмөр эрхлээгүй үеийн тэтгэмж
- хүн асарсны тэтгэмж
- жирэмсний ба хүүхэд төрсний дараах тэнцүүлэн нөхөн олгох тэтгэмж
- хүүхэд төрүүлсний дараах мөнгөн тусламж

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ:

Хуулийн дагуу тэтгэврийн даатгалд оролцсон хүмүүс өндөр насны, тахир дутуу, тэжээгч алдсны тохиолдолд мөнгөн тусламж олгоно.

Тэтгэврийн үндсэн даатгалаас олгоно:

- өндөр насны тэтгэвэр
- тахир дутуу тэтгэвэр
- бэлэвсний тэтгэвэр ба тэжээгчээ алдсны тэтгэвэр

Дэлгэрэнгүй:

Okresní správa sociálního zabezpečení Chomutov

Хомутов хотын окресийн нийгмийн хангамжийн газар

хаяг: Roháčova 4183, 430 03 Chomutov

Утас: 474 637 511, 474 637 611

E-мэйл: posta.cv@cssz.cz

www: <http://www.cssz.cz/cz/kontakty/>

АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭЛЭГ:

Чех улсын иргэд болон Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлтэй юмуу орогнох эрх эсвэл нэмэлт хамгаалалттай байгаа гадаадын иргэд **хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд** бүртгүүлж болно. Хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд бүртгүүлснээс өмнө сүүлийн 2 жилийн турш доод тал нь 12 сар ажилласан бүртгэлд байгаа хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагч ажил хөдөлмөр эрхлээгүй үед ажилгүйдлийн тэтгэлэг авах эрхтэй.



Хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд бүртгүүлэхэд:

- хувийн үнэмлэх (оршин суух зөвшөөрөл, паспорт)
- хөдөлмөрийн харьцаа дуусгавар болсон тухай бичиг баримт
- хувиара хөдөлмөр эрхэлдэг этгээдүүд тэтгэмжийн даатгалд дураараа оролцсоны тухай бичиг баримт (үргэлжилсэн хугацаа, төлсөн хэмжээ)
- жирэмсний зэрэг адилхан амралт дууссаны тухай ыичиг баримт
- ажил хийсэн тухай тодорхойлолт (zápočtový list) болон сарын цэвэр дундаж цалингийн тухай тодорхойлолт

Дэлгэрэнгүй:

Úřad práce České republiky, Krajská pobočka v Ústí nad Labem

Чех улсын хөдөлмөрийн товчоо, Усти над Лабем мужийн салбар

Kontaktní pracoviště Chomutov

Хомутовд байгаа товчоо

хаяг: Cihlářská 4107, 430 03 Chomutov

Утас: 950 118 111

Е-мэйл: chomutov@cv.mpsv.cz

www: <http://portal.mpsv.cz/upcr/kp/ulk/kop/chomutov>

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН СИСТЕМ 2

ДААТГАЛГҮЙ НИЙГМИЙН ТЭТГЭЛЭГ:

Хөдөлмөрийн товчоонд даатгалгүй нийгмийн тэтгэлэг олгох тухай өргөдөл гаргаж болно:

- **улсын нийгмийн тэтгэмж** (хүүхэд олгох тэтгэмж, эцэг эхэд олгох тэтгэмж, орон байранд өгөх тэтгэмж, амаржсаны тэтгэмж, оршуулганы тэтгэмж)
- **материаллаг гачигдалд туслах тэтгэлэг** (хангалттай орлогогүй - амь зуухад олгох тэтгэлэг, орон байранд олгох зөрүү мөнгө, даруй олгох онцгой тусламж)
- **арчилгааны тэтгэлэг** (удаан хугацаагаар эрүүл мэндийн хувьд тааламжгүй нөхцөлд байгаа өөр хүний асрамжнаас хамааралтай 1-ээс настай хүмүүст зориулагдсан)
- **тахир дутуу болсон хүний тэтгэлэг** (хөдөлгөөний тэтгэлэг, тусгай төхөөрөмжийн тэтгэлэг, тахир дутуу хүний үнэмлэх болон үүнээс гарсан ашиг олз)
- **хүүхэд асрамжинд авч асарсны тэтгэмж** (хүүхдийн хэрэгцээнд зарцуулах тэтгэмж, хүүхэд асарсны шагнал, хүүхдийг хүлээж авахад өгөх тэтгэмж ба моторт тээврийн хэрэгсэл худалдаж авахад тэтгэмж)

Улсын нийгмийн тэтгэмжийн мөнгө хэрэв хүн (орлого нь тогтоогдох мөнгөн тусламж, хамт тооцогддог хүмүүсийн ч) Чех улсын нутаг дэвсгэрт байнга/удаан хугацаагаар оршин суудаг бол олгогдоно. Улсын нийгмийн тэтгэмжийн тухай хуулийн зорилгод байнга оршин суугаа хүмүүс гэж Чех улсын нутаг дэвсгэрт 365 -аас дээш хоног оршин суухаар хамаарагдах хүмүүс болох гадаадын иргэдийг бас ойлгоно.

Мөнгөн тусламж олгох эсэх тухай шийдвэрлэхэд гэр бүлийн өмчийг харгалздаггүй, зөвхөн зарим мөнгөн тусламжийг олгоход орлогыг харгалздаг. Өргөдлөө гаргахад хувийн үнэмлэх үзүүлэх болон тусгай ыичиг баримтууд өгөх ёстой.

Дэлгэрэнгүй:

Úřad práce České republiky, Krajská pobočka v Ústí nad Labem

Чех улсын хөдөлмөрийн товчоо, Усти над Лабем мужийн салбар

Kontaktní pracoviště Chomutov Хомутовд байгаа товчоо

хаяг: Cihlářská 4107, 430 03 Chomutov

Утас: 950 118 511 (улсын нийгмийн тэтгэмж)

Magistrát města Chomutova, Kontaktní pracoviště Úřadu práce Chomutov

Хомутов хотын захиргааны газар, Хомутов хотын хөдөлмөрийн товчооны салбар

хаяг: Zborovská 4602, 430 28 Chomutov

Утас: 950 118 522 (материаллаг гачигдалд туслах тэтгэлэг, арчилгааны тэтгэлэг, тахир дутуу болсон хүний тэтгэлэг)

Е-мэйл: chomutov@cv.mpsv.cz

www: <http://portal.mpsv.cz/upcr/kp/ulk/kop/chomutov>

НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД:

Нийгмийн үйлчилгээнүүд урьдчилсан ажиллагаа болон нийгэмд оролцох зориулж тусламж үйлчилгээнүүд байна. Нийгмийн үйлчилгээнүүдийн 3 төрөл зүй:

- а) нийгмийн зөвлөгөө
- б) нийгмийн арчилгааны үйлчилгээ
- с) урьдчилан сэргийлэх нийгмийн үйлчилгээ



Magistrát města Chomutova Хомүтов хотын захиргааны газар**Odbor sociálních věcí Нийгмийн хэргийн хэлтэс**

хаяг: Zborovská 4602, 430 28 Chomutov

Утас: 474 637 164, 474 637 207

Е-мэйл: podatelna@chomutov-mesto.cz

www: <http://www.chomutov-mesto.cz>

Sociální služby Chomutov, p. o.**Хомүтов хотын Нийгмийн үйлчилгээ, абб**

хаяг: Písečná 5030, 430 04 Chomutov

Утас: 474 623 261

Е-мэйл: soschomutov@soschomutov.cz

www: <http://www.soschomutov.cz>

Světlo Kadaň, o. s. „Кадань гэрэл“, үк**a) Sociální centrum Kamíněk нийгмийн товчоо**

хаяг: Školní pěšina 5249, 430 04 Chomutov

Утас: 725 758 588

Е-мэйл: kdarova@os-svetlo.net

www: <http://www.kaminek-chomutov.cz>

b) K-centrum Chomutov s terénním programem**Газар нутгийн програмтай Хомүтов хотын К-төв**

хаяг: Hálkova 224, 430 01 Chomutov

Утас: 725 543 162

Е-мэйл: kcchomutov@os-svetlo.net

www: <http://www.os-svetlo.net/>

Fond ohrožených dětí**Сөнөн мөхөх аюул тулгараад байгаа хүүхдүүдийн сан**

хаяг: Kamenný vrch 5307, 430 04 Chomutov

Утас: 724 667 648, 724 567 000

Е-мэйл: fod.chomutov@fod.cz

www: <http://www.fod.cz>

Oblastní charita Most – Poradna Chomutov**Мост мужийн Харита – Хомүтов хотод байгаа зөвлөгөө өгөх товчоо**

хаяг: 17. listopadu 5461, 430 04 Chomutov

Утас: 476 119 999, 603 148 127

Е-мэйл: charita@charitamost.cz

www: <http://www.charitamost.cz>

Člověk v tísni, o. p. s. Сүйрлийн ирмэгт байгаа хүн, абб**Pobočka Chomutov Хомүтов хотын товчоо**

хаяг: Nerudova 1, 430 01 Chomutov

Утас: 411 140 170

Е-мэйл: marketa.dolejsi@clovekvtsni.cz

www: <http://www.clovekvtsni.cz/cs/socialni-prace/pobocka/chomutov>

Spirála, o. s. Спираль, үк**Intervenční centrum pro osoby ohrožené domácím násilím**

гэр бүлийн хүчирхийлэл тулгараад байгаа хүмүүсийн хэрэгт

хөндлөнгөөс оролцох товчоо

Budova Sociálních služeb, p. o. Нийгмийн үйлчилгээний төв

хаяг: Písečná 5030, 430 04 Chomutov

Středa 10.00–14.00 hod. Лхагвад 10 – 14 цагт

Утас: 475 511 811

Е-мэйл: spirala.cki@volny.cz

www: <http://www.spirala-ul.cz>

Diecézní charita Litoměřice, Charitní ošetřovatelská**a pečovatelská služba Chomutov**

Литомерице хотын Харита, Хомүтов хотын асаргаа сувилгааны үйлчилгээ

хаяг: Březenecská 4804, 430 04 Chomutov

Утас: 474 686 195, 731 402 445

Е-мэйл: chops.chomutov@dchltm.cz

www: <http://www.dchltm.cz>

Centrum pomoci pro zdravotně postižené a seniory, o. p. s.

Тахир дутуу болон өндөр насны хүмүүст тусламж үзүүлэх товчоо, абб

хаяг: Kochova 1185, 430 12 Chomutov

Утас: 474 332 816, 606 156 714

Е-мэйл: centrumpomoci@seznam.cz

www: <http://www.centrumpomoci.cz>

Penzion Pod Břizami, s. r. o. (domov se zvláštním režimem)

Хүс модон доорх зочид буудал, ххк – тусгай дэглэмтэй асрах газар

хаяг: Pod Břizami 5598, 430 04 Chomutov

Утас: 773 929 215

Е-мэйл: penzionpodbrizami@seznam.cz

www: <http://penzionpodbrizami.webnode.cz>

Raná péče Diakonie Stodůlky эртний асрамж

(pro rodiny se zdravotně handicapovaným dítětem)

тахир дутуу хүүхэдтэй гэр бүлд үзүүлсэн асаргаа сувилгаа

působnost v okrese Chomutov

Хомүтов мужид үзүүлсэн үйлчилгээ

хаяг: Vlachova 1502, 155 00 Praha 5 – Stodůlky

Утас: 235 518 392, 731 445 504

Е-мэйл: stodulky@rana-pece.cz

www: <http://www.rana-pece.cz>

